



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 07 сарын 09 өдөр


Дугаар A/59

Улаанбаатар хот

Г Улаанбаатар хотын аялал жуулчлалын танилцуулга хийх тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 01/19 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 1.42, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/622 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.5.3 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах зорилгоор Улаанбаатар хотын аялал жуулчлалын танилцуулга хийх ажлыг хариуцан зохион байгуулахыг Мэдээлэл, сурталчилгааны хэлтэс /Д.Жавхлан/-т даалгасугай.
2. Улаанбаатар хотын аялал жуулчлалын танилцуулга хийх ажлыг хариуцан зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Улаанбаатар хотын аялал жуулчлалын танилцуулга хийхэд шаардагдах төсөв болох 41 500 000 /дөчин нэгэн сая таван зуун мянга/ төгрөгийг Нийслэлийн 2018 оны төсөвт тусгасан “Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болгох арга хэмжээний зардал”-аас гаргахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.
4. Арга хэмжээний үеэр хамтран ажиллах, гэрээ байгуулах байгууллагуудыг судалж, 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс өмнө танилцуулахыг Ажлын хэсэг /Д.Жавхлан/-т даалгасугай.





Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 07
сарын 09 өдрийн А/59 дүгээр
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СВТ 48936 1118263502

УЛААНБААТАР ХОТЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТАНИЛЦУУЛГА ХИЙХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга	Д.Жавхлан	/Мэдээлэл, сурталчилгааны хэлстийн дарга /
Гишүүд	З.Оюуншүр С.Баяржаргал Б.Ербахыт	/Хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн/ /Мэдээлэл, сурталчилгааны төвийн менежер/ /Статистик, сургалт, судалгаа хариуцсан мэргэжилтэн/
Нарийн бичгийн дарга	Г.Азжаргал	/Олон нийтийн харилцаа хариуцсан мэргэжилтэн/

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 07
сарын 09 өдрийн А/59 дүгээр
тушаалын хоёрдугаар хавсралт

5284325 СБТ-42936' 1118263502

УЛААНБААТАР ХОТЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ТАНИЛЦУУЛГА ХИЙХ ТӨСӨВ

№	Зардлын зүйл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	"Улаанбаатар жуулчны хөтөч" гарын авлага /120 нүүртэй, урт 18,8, өргөн 12,8 см хэмжээтэй/	5 000	4 000 төгрөг	20 000 000 төгрөг
2	Улаанбаатар хотын газрын зураг / эвхмэл 10,5 см*7 см хэмжээтэй/	10 000	750 төгрөг	7 500 000 төгрөг
3	Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний газрын зураг /дэлгэмэл В3 хэмжээтэй/	10 000	400 төгрөг	4 000 000 төгрөг
4	www.visitulaanbaatar.mn цахим хуудасны хөгжүүлэлт	-	10 000 000 төгрөг	10 000 000 төгрөг
НИЙТ ДҮН				41 500 000 төгрөг